# ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 28 өдөр Дугаар А/24 Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гааль, Татварын ерөнхий газрын 2016 оны “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Сайнбуян/-т, шаардагдах хөрөнгийн зардлыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Төгсжаргал/-т, хэрэгжилтийн ил тод байдлыг ханган, тухай бүрт нь цахим мэдээллийн сүлжээнд байршуулахыг Олон нийттэй харилцах хэлтэст даалгасугай.

3. Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг хагас жил, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Сайнбуян/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.НУРЭВ

*Хавсралт-1*

БАТЛАВ. ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ПҮРЭВ

# ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2016 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот 2016.01.28

| Дэд хэсэг | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | | | Хариуцах эзэн | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хүн хүч | Хөрөнгө, санхүү | Хугацаа | Гүйцэтгэлийн үзүүлэлт | | |
| **1.Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт** | | | | | | | | |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2. | 1.1. Гааль, татварын ерөнхий газрын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах | 10 Хүн/өдөр | - | 1, 2 сар | - Гааль, татварын ерөнхий газрын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батласан байх | ТЗУГ, нэгж, дэргэдэх байгууллага | Албан хаагчид, олон нийтэд шударгаар ажиллаж, хуулиар хүлээсэн үүргийг биелүүлэх итгэл үнэмшил бий болно |
| | | 1.2. Хагас, бүтэн жилээр төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах | | - | 7 дугаар сарын 10, 11 сарын 5 | - Төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргах, тайланг нэгтгэх<br>- Тайланг удирдлагад танилцуулах | ТЗУГ, нэгж, дэргэдэх байгууллага | |
| | | 1.2. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг тусгайлан төлөвлөж, санхүүжүүлэх, тусгасан арга хэмжээг цаг, хугацаанд нь хэрэгжүүлэх | | 5000000 төгрөг | 1 улирал, 8 сар | - Батлагдсан төсвийг зарцуулж ажилласан байх<br>- Зарцуулсан арга хэмжээг цаг, хугацаанд нь хэрэгжүүлсэн байх | ТЗУГ, СХОГ | |
| | | 1.3. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, яриа таниулга, сонсгол, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/ | | - | Жилдээ | - Байгууллагын цахим хуудсаар болон бусад хэлбэрээр сурталчилсан байх<br>- Иргэд, байгууллагын зүгээс чөлөөтэй авах нөхцөлийг хангасан байх | ТЗУГ, нэгж, дэргэдэх байгууллага | |
| | | 1.3. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны | | - | Жилдээ | - Сурталчилгааны материалыг түгээсэн байх | ТЗУГ, ОНХХ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх | | | | | | |
| 2 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох<br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 | 2.1.Боловсруулж байгаа нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах, цахим хуудсандаа байршуулсан байх | 14 Хүн/өдөр | - | Жилдээ | - Байгууллагын цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх, ирсэн санал шүүмжийг тусгах | МТТ, ХЭЗГ, ОНХХ | Шударга байдлын түвшин нэмэгдэж, ил тод нээлттэй байдлыг хангасан байна |
| 3 | Гааль, Татварын ерөнхий газрын хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 | 3.1. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд тухайн жилд явуулах хяналт шалгалтын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар хийх ажлын төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах | Багаар | 300000 төгрөг | Жилдээ | - Хяналт шалгалтын төлөвлөгөөг гаргана<br>- Төлөвлөгөөт бус шалгалтын төлөвлөгөөг тухай бүр гаргаж, удирдлагаар хянуулан удирдамжийн дагуу шалгана<br>- Орон нутагт, нэгжид төлөвлөгөөний дагуу ажиллана<br>- Цахим хуудсанд байршуулна | ХШҮДАГ | |
| | | 3.2. Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн байх | | | | - Шалгалтын үр дүн, дүгнэлтийг удирдлагад танилцуулж, шалгалтын мөрөөр хийх ажлыг төлөвлөнө<br>- Дүнг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлсэн байна | ХШҮДАГ, ОНХХ, | |
| | | 3.3.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн | | | | - Хяналт шалгалтын дүгнэлт, актанд тулгуурлан зөвлөмж гаргасан байна.<br>- Үр дүнг мэдээлсэн байна | ХШҮДАГ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | талаар мэдээлсэн байх | | | | - Цахим сайтад байршуулна | | |
| 4 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаар/<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 | 4.1. Тухайн жилийн төсөв | 5 Хүн/өдөр | - | 1 сарын 10-ны дотор | Шилэн дансны хуулийн дагуу хугацаанд байгууллагын цахим “Шилэн данс”-нд байршуулсан байна | СХОХ | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, ил тод нээлттэй байдлын шалгуурыг хангасан байна |
| | | 4.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл | | - | 4 сарын 1-ний дотор | | | |
| | | 4.3. Сарын төсвийн гүйцэтгэл | | - | Дараа сарын 8-ны дотор | | | |
| | | 4.4. Улирлын төсвийн гүйцэтгэл | | - | | | | |
| | | 4.5. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл | | - | 8 сарын 15-ны дотор | | | |
| | | 4.6. Хагас жилийн санхүүгийн тайлан | | - | | | | |
| | | 4.7. Дараа жилийн төсвийн төсөл | | - | 9 сарын 15-ны дотор | | | |
| | | 4.8. Жилийн эцсийн санхүүгийн тайлан | | - | 4 сарын 25-ны дотор | | | |
| | | 4.9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | 5 Хүн/өдөр | - | 4 сарын 25-ны дотор | | | |
| | | 4.10. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | | - | 7 сарын 1-ний дотор | | | |
| | | 4.11. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | 5 Хүн/өдөр | - | улирал бүр | | | |
| | | 4.12. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | | - | Өөрчлөлт орсноос хойш ажлын 7т | | | |
| | | 4.13. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох | | - | Тухай бүр | | ГТТГ, ОГ | |
| | | 4.14. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт | | - | Өөрчлөлт орсноос хойш 7т | | ГТТГ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 4.15. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | 5 Хүн/өдөр | - | Гүйлгээ хийснээс хойш 7т | | СХОГ, ҮААГ | |
| | | 4.16. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | | - | Өөрчлөлт орсноос хойш 7т | | ТЗУГ, ХНХ | |
| | | 4.18.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуулах | 5 Хүн/өдөр | - | Өөрчлөлт орсноос хойш 1т | | СХОГ, ҮААГ | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, ил тод нээлттэй байдлын шалгуурыг хангасан байна |
| | | 4.20. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл | 5 Хүн/өдөр | - | Тухай бүр | | СХОХ, ГХАХ, МТТ | |
| 5 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 | 5.1. Гаалийн зуучлагч, гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх /гаалийн баталгаат агуулах, үйлдвэрийн газар, үзэсгэлэнгийн газар, барилгын талбай, тусгай бүс, татваргүй барааны дэлгүүр/, гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн жагсаалтыг ил тод цахим хуудсандаа байршуулах<br>5.2.Дээрх зөвшөөрлийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах,<br>5.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа байршуулах | 5 Хүн/өдөр | - | Тухай бүр | - Жагсаалтыг цахим хуудсанд байршуулна<br>- Зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт болон журмыг цахим хуудсанд байршуулна<br>- Эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд байршуулсан байна | ГХБГ | Шударга байдлын түвшин нэмэгдсэн байна |
| 6 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах<br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн | 6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах | 10 Хүн өдөр | 100000 төгрөг | Тухай бүр | - Байгууллагын цахим хуудас,<br>- Мэдээллийн самбар,<br>- Өдөр тутмын хэвлэлд байршуулна | ТЗУГ, ХНХ | |
| | | 6.2. Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх | | 100000 төгрөг | Тухай бүр | - Сонгон шалгаруулалтыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, өдөр | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6 дугаар зүйлийн 6.1.5;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл | | | | | тутмын хэвлэлүүдэд байршуулна | | |
| 7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;<br>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;<br>• Төрийн болон орон нут-гийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5 | 7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсандаа байршуулах | 20 Хүн/өдөр | - | 1 сарын 10-ны дотор | - Нийтэд мэдээлсэн байна | СХОГ ҮААГ | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, ил тод нээлттэй байдлын шалгуурыг хангасан байна |
| | | 7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх | | | Жилдээ | - Тендер шалгаруулалтын журам, урилгыг цахим хуудсанд байршуулна<br>- Төлөөллийг оролцуулсан байна | | |
| | | 7.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл болон шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг жагсаалтаар цахим хуудсанд байршуулах | | | Тухай бүр | - Цахим хуудсанд байршуулсан байна | | |
| | | 7.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах | 7 Хүн/өдөр | - | Сар бүр | - Цахим хуудсанд байршуулсан байна | | |
| | | 7.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулах | | - | Тухай бүр | - Тайлан, дүгнэлт болон шалгалтын дүнг цахим хуудсанд байршуулна | | |
| | | 7.6. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх | 5 Хүн/өдөр | - | Тухай бүр | - Төлөөллийг оролцуулна<br>- Энэ талаар нийтэд мэдээлсэн байна | | |
| 8 | Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох<br><br>Эрх зүйн үндэслэл: | 8.1.Гааль, татварын албан хаагчдын ажлын чиг үүргийн хүрээнд ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх, нэгжийн хүрээнд албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг баталсан байх | 14 Хүн/өдөр | - | Жилдээ | - Ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдсөн байна | ТЗУГ, ХНХ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 10.5.Салбар ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх | | - | 7 сар 10, 11 сар 5 | - Хагас, бүтэн жилээр үнэлсэн байна | | Шударга байдлын түвшин нэмэгдсэн байна |
| 11 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл;<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6 | 11.1. Гааль, татварын ерөнхий газар болсонтой холбогдуулан "Сахилга, ёс зүйн хороо"-г шинээр байгуулах, хорооны үйл ажиллагааны дүрмийг шинэчлэн батлуулах, | 14 Хүн/өдөр | - | I улирал | - Сахилга, ёс зүйн хороо"-г шинээр байгуулсан байна<br>- Хамт олонд танилцуулсан байна | ХЭЗГ, ОНХХ | |
| | | 11.2. "Гааль, татварын ажилтны ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн боловсруулах, Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан | | - | Жилдээ | - Хууль, эрх зүйн газар төслийг боловсруулна<br>- АТГ-аас санал авсан байна | | |
| | | 11.3. "Гааль, татварын ажилтны ёс зүйн дүрэм"-ийг батлах, мөрдүүлж, албан хаагчдад танилцуулсан байх | | - | Жилдээ | - Ёс зүйн дүрмийг батласан байна<br>- Албан хаагчдад танилцуулж, мөрдөнө | | |
| | | 11.4. Гааль, татварын ажилтны зөрчлийн талаарх мэдээллийг тогтмол утас ажиллуулан хүлээн авах, ирсэн мэдээллийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд ил тод байршуулах | | - | Тухай бүр | - Тогтмол утас ажиллуулах<br>- Ирсэн мэдээллийг шийдвэрлэсэн байна<br>- Ил тод байршуулна | | |
| | | 11.5.Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | | - | Жилдээ | - Урьдчилан сэргийлж зөвлөмж хүргүүлнэ | | |
| | | 11.6.Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх | | - | Тухай бүр | - Зөрчил үүссэн бол хариуцлага тооцон ажиллана | | |
| | | 11.7. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлж, ёс зүйн зөрчлийн мэдээг гарган Төрийн албаны зөвлөл болон Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх | | - | Хагас, бүтэн жил | - Мэдээлсэн байна | | |
| 12 | Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс | 12.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулах | 7 Хүн/өдөр | - | Жилдээ | - Давхар ажил эрхлэлтийн жагсаалтыг танилцуулна | ТЗУГ, ХНХ | |
| | | 12.2.Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох | | - | Тухай бүр | - Судалгааг гаргасан байна<br>- Зөвшөөрөл авсан байна | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл | | | | | | | |
| 13 | Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5 | 13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг цахим хуудсаар бүрдүүлэх | 20 Хүн/өдөр | - | Жилдээ | - Цахим хуудсанд байршуулсан байна | ОНХХ | Шударга байдлын түвшин нэмэгдсэн байна |
| | | 13.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах | 14 Хүн/өдөр | - | Тухай бүр | | | |
| | | 13.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавρыг цахим хуудсандаа байршуулах | | - | Тухай бүр | - Холбогдох хууль тогтоомжийг цахим хуудсанд байршуулах | | |
| | | 13.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах | | - | Жилдээ | - Төлбөр, хураамжийн жагсаалтыг цахим хуудсанд байршуулна | ГХБГ<br>ОНХХ | |
| 14 | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах<br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар | 14.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх | 20 Хүн/өдөр | 1000000 | Жилдээ | - Цахим хуудсанд байршуулж, сурталчилна | ОНХХ | |
| | | 14.2.Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар гэх мэт хэлбэрээр хүлээн авах | | - | Жилдээ | - Хүлээн авах боломжийг бүхий л хэлбэрээр бүрдүүлсэн байна | ТЗУГ<br>ОНХХ | |
| | | 14.3.Олон нийттэй харилцах албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах | | - | Жилдээ | - Цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан байна | ТЗУГ<br>ОНХХ | |
| | | 14.4.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар цахим сайтаар мэдээллэх | | - | Тухай бүр | - Шийдвэрлэлтийн талаар ил тод мэдээлсэн байна | ТЗУГ<br>ОНХХ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зүйлийн 7.2.3;<br>• Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг | | | | | | | |
| 15 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 | 15.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах | 14<br>Хүн/өдөр | - | Жилдээ | - Жагсаалтыг гаргаж, АТГ-т хүргүүлсэн байна | ХЭЗГ | |
| | | 15.2.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах, хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах | | - | Жилдээ | - Хүнд сурталгүй ажиллах<br>- Хуулийн хүрээнд улсын байцаагчийг сэлгэн ажиллуулах<br>- Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянасан байна | ТЗУГ<br>ХНХ | |
| 16 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 | 16.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ авах | 20<br>Хүн/өдөр | - | Тухай бүр | - Зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж ажиллана | ТЗУГ | |
| | | 16.2.АТГ-аас болон холбогдох албан тушаалтнаас зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ | | - | Тухай бүр | - Мэдэгдлийн дагуу биелэлтийг хангасан байна | ТЗУГ | |
| | | 16.3.АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ | | - | Тухай бүр | - Арга хэмжээг холбогдох журмын дагуу авсан байна | ТЗУГ | |
| **2.Авлигатай тэмцэх санал, санаачилга** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх<br>Эрх зүйн үндэслэл:<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2; | 17.1. Хэрэгжилтийн тайланг 11 сарын 15-ны дотор АТГ-т хүргүүлэх | 14 Хүн/өдөр | - | 11 сар 15 | - Тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна | ТЗУГ | Хариуцлагын тогтолцоо сайжирч, авлигаас ангид байж, шударга ёсыг эрхэмлэнэ |
| | | 17.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх | | - | 11 сар 15 | - Тайланд ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хийх ажлын саналыг тусгасан байна | | |
| 18 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт | 18.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, уриалгад нэгдсэн байдал | 14 Хүн/өдөр | 500000 төгрөг | Жилдээ | - Хамтран ажиллаж, гарсан үр дүнг нийтэд мэдээлсэн байна<br>- Хамтарсан уриалга гарган албан хаагчдыг хамруулсан байна | ОНХХ | |
| | | 18.2.Гааль, татварын ерөнхий газар, дэргэдэх байгууллага, нэгжийн удирдах албан тушаалтнууд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлээ илэрхийлж, шударга ёсыг тогоох, авлига хүнд сурталгүй ажиллах, энэ талаар хүчин чармайлт, санаачилга гаргаж, албан хаагчдад үлгэр жишээ үзүүлэн ажиллах | | 500000 төгрөг | Жилдээ | - Удирдах ажилтны зөвлөлгөөний үеэр Гааль, татварын ерөнхий газар болон дэргэдэх байгууллага, нэгжийн удирдлагууд авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэн үр дүнгийн гэрээний бүтээгдэхүүнд тусган ажиллана<br>- АТГ-ын ажилтан болон авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлийн сургагч багшаар удирдлагын хэмжээнд сургалт зохион байгуулсан байна | ТЗУГ, нэгж, дэргэдэх байгууллага | |
| | | 18.3. Гааль, татварын ерөнхий газар, дэргэдэх байгууллага, нэгжийн удирдах албан тушаалтнууд авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргаж ажиллах | | - | Жилдээ | - Нэгжийн хэмжээнд авлигын эсрэг ажил зохион байгуулах, түүнд тусгайлан төсөв зарцуулсан байна | ТЗУГ, нэгж, дэргэдэх байгууллага | |
| | | 18.4.Удирдлагын хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаас үнэлгээ авах, үр дүнг илтгэх | | - | 3 улирал | - Албан хаагчдаас удирдлагын авлигаас ангид хэрхэн ажилласан талаар үнэлгээ авч үр дүнг илтгэнэ | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | 19.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх талаар авах арга хэмжээ авч ажиллах | 10 Хүн/өдөр | 500000 төгрөг | Жилдээ | - "Шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчил"-ийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг зохион байгуулсан байна.<br>- АТГ-тай хамтран сургалт зохион байгуулна | ТЗУГ, СТ | |
| | | 19.2.Улсын байцаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох, ёс зүйг сахиулж ажиллах | | - | Жилдээ | - Улсын байцаагчдын ажлын гүйцэтгэлийг сар, улирал хагас, бүтэн жилээр шалгуурын дагуу үнэлэх<br>- Иргэдээс албан хаагчдын ёс зүйн үзүүлэлтээр санал авч, хяналт тавьсан байна | ТЗУГ ХНХ ХШҮДАГ | |
| | | 19.3.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд авлигын зөрчил илрүүлж, таслан зогсоох, "Сахилга, ёс зүйн хороо"-нд тайлагнах, холбогдох арга хэмжээг авсан байх | | - | Жилдээ | - Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулна<br>- Зөрчилийг "Сахилга, ёс зүйн хороо"-оор хэлэлцэх, хариуцлага тооцсон байна | ХШҮДАГ | |

**ХЯНАСАН:**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.САЙНБУЯН

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДОРЖСҮРЭН

**БОЛОВСРУУЛСАН:**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН УЛСЫН БАЙЦААГЧ, ЭБАТ Э.АЛТАНЗУЛ

Э.ПҮРЭВДУЛАМ